

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Код 13.020.50

Үндэсний эко-тэмдэг Техникийн шаардлага, хэлбэр хэмжээ National eco-label From, sizes and technical requirements	MNS 5600:2003
---	---------------

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2003 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2003 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү стандарт нь зөвлөмжийн байна.

1. Хамрах хүрээ

Энэ стандартаар зохих хууль тогтоомжийг үндэслэн бүтээгдэхүүн, бусад шаардлагатай объектод баталгаажуулалтын тогтоосон журмын дагуу хэрэглэж ашиглах Үндэсний эко-тэмдэг (буоу эко-марк)-ийн хэлбэр, хэмжээ, түүнд тавих техникийн ерөнхий шаардлагыг тогтооно.

2. Норматив ишлэл

Норматив дараахь баримт бичиг нь энэхүү стандартын загвар, агууллыг хянахад лавлагaa болж өгнө. Он сар өдөр заасан лавлагaa, нэмэлт өөрчлөлт оруулсан, хянаж засварласан төслийн хувилбарын алиныг ч үүнд хэрэглэхгүй. Хэлэлцээр байгуулагч талууд энэхүү стандартыг үндэслэл болгох, зөвшөөрөх үед дор дурдсан стандартын хамгийн сүүлийн үеийн хэвлэлийг ашиглах боломжийг судлахад дэмжлэг болно.

Дор дурдаж, хэвлэсэн хүчин төгөлдөр норматив баримт бичгийн хамгийн сүүлийн үеийн хэвлэлийг хамааруулж ашиглана. Үүнд:

- MNS ISO 14020:1998, Байгаль орчны эко-тэмдэг ба мэдэгдэл – Ерөнхий зарчим;
- MNS ISO 14021:1999, Байгаль орчны эко-тэмдэг ба мэдэгдэл – Байгаль орчны талаархи мэдүүлэг (Байгаль орчны эко-тэмдэг хэрэглэх II заавар);
- MNS ISO 14024:1999, Байгаль орчны эко-тэмдэг ба мэдэгдэл – Байгаль орчны эко-тэмдэг – Зарчим ба журам;
- MNS ISO/TR 14025:2001, Байгаль орчны эко-тэмдэг ба мэдэгдэл

- Байгаль орчны талаархи мэдэгдэл (Байгаль орчны эко-тэмдэг хэрэглэх III заавар). Техникийн тайлан;
- MNS ISO 14040:1997, Байгаль орчны менежмент – “Амьдрал”-ын мөчлөг – Бүтэц ба зарчим;

3. Техникийн шаардлага

- 3.1. Үндэсний эко-тэмдгийн еренхий дурс хэлбэрийг Стандартчиллын төв байгууллагын шийдвэрээр баталж, MNS ISO 14024 стандартыг баримтлан эрх бүхий байгууллагад зохих журмын дагуу бүртгүүлсэн байна.
- 3.2. Энэхүү эко-тэмдгийг эзэмшигч нь Стандартчиллын төв байгууллага байх бөгөөд түүний зөвшөөрлөөр түр ашиглагч ямар нэг байгууллага, хэрэглэгч байж болно.
- 3.3. Холбогдох стандарт, норматив бусад баримт бичигт тухайн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ, эсхүл байгууллага (цаашид бүтээдэгхүүн гэх) нь бүрэн тохирч буйг нотолж, тухайн аж ахуйн нэгж, байгууллага (цаашид эко-тэмдэг ашиглагч гэх)-д Үндэсний эко-тэмдэг (буюу эко-марк)-ийг хэрэглэх эрхийг тодорхой хугацаатайгаар, гэрээний үндсэн дээр уг эко-тэмдгийг эзэмшигч (3.2-т заасан)-ээс олгоно.
- 3.4. Эко-тэмдэг ашиглагч нь баталгаажуулсан (буюу эко-тэмдэг хэрэглэх эрх авсан) бүтээгдэхүүнд, эсхүл түүний сав, баглаа боодол, хаяг, шошго дээр болон цех, үйлдвэрийн байр, оршин буй байрлалд нь, эсхүл шошго дээрх барааны тэмдгийн ойролцоо зайд уг эко-тэмдгийг зурж байрлуулан мэдээлэл сурталчилгаанд хэрэглэх эрхтэй. Мөн тэмдгийн тухай олон нийт, хэрэглэгчдэд зориулан нийтлэл гаргах, ухуулах, эсхүл найдвартай, үнэн зөв, төөрөгдүүлэхээргүй мэдээлэл болгож өгөхүйц тохиромжтой байр буюу байрлалд зурах, сийлэх, хэвлэх, барлах, хатгах зэрэг хувилбараар эко-тэмдгийн хэлбэр дүрсийг гаргах талаар технологийн янз бүрийн аргыг хэрэглэнэ.
- 3.5. Үндэсний эко-тэмдэгтэй бүтээгдэхүүн хүний эрүүл мэнд, байгаль орчинд цэвэр, аюулгүй бөгөөд амьтан, ургамалд сөрөг нелөөгүйг хөндлөнгийн эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрсөн, зохих стандартын шаардлагад тохирч буйг илэрхийлнэ.
- 3.6. Эко-тэмдгийн хэлбэр нь өнгө зохицоо, дүрс хослол сайтай, суурь өнгөнөөс тод ялгарч, цэвэрхэн харагдахуйц, дүрслэгдсэн, аливаа тохиолдолд арилахгүй байвал зохино.

- 3.7. Аливаа үйлдвэрлэгч, эсхүл байгууллага буюу эко-тэмдэг эзэмшигчээс эко-тэмдгийг хууль бусаар, эсхүл энэхүү стандартын шаардлагыг зөрчиж хэрэглэхгүй байна.
- 3.8. Энэхүү стандартын заалт болон эко-тэмдэг эзэмшигчтэй байгуулсан гэрээний биелэлтэд түүнийг байгуулсан Талуудаас хууль тогтоомжинд өөрөөр заагаагүй бол хяналт тавьж ажиллана.
- 3.9. Эрх авсан аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн бүтээгдэхүүнд, эсхүл түүний хаяг, шошго дээр эко-тэмдгийг "заавал хэрэглүүлэх шаардлага" тавихгүй.
- 3.10. Эко-тэмдэг ашиглагч тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь эко-тэмдэг хэрэглэх эрхийн хугацаа дууссан, эсхүл өөр шалтгаанаар уг эрхээ хасуулсан, эсхүл мөн эрхийн хугацааг түдгэлзүүлэх буюу түр зогсоох тохиолдолд холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу эко-тэмдэг хэрэглэх эрхгүй.
- 3.11. Эко-тэмдгийг гэрээ – эрхийн харилцаа, олон талын хамтын ажиллагаанд тодорхой зорилго, зориулалтаар ашиглаж болно.

4. Хэлбэр, хэмжээ

- 4.1. Эко-тэмдгийн хэлбэр дүрс дээр бичигдэх үг, үсгүүдийг дармал бичлэгийг ашиглаж, энэхүү стандартаар заасан техникийн шаардлагыг баримтлан гүйцэтгэнэ.
- 4.2. Эко-тэмдгийн хэлбэр, түүний зөв харьцаа нь дор дурдсан зургаар үлгэр болгон үзүүлсэнтэй тохирч байна. Энэхүү стандартаар заасан эко-тэмдгийн хэлбэр, хэмжээ, өгөгдсөн харьцаа нь суурь үндэслэл болж, түүнийг ашиглагчдад болон бусад хэрэглэгчдэд үлгэр авах, сонголт хийх, зөв буулгахад зориулагдана.



Зураг

Тайлбар: 1. Үндэсний эко-тэмдгийн загвар нь "монголын экологи"-т тухайн бүлтээгдэхүүн (ажил, үйлчилгээ эсхүл объект) нь байгальдаа цэвэрхэн, түүнчлэн хүн, амьтан, ургамал, хөрсөнд аюулгүйг илэрхийлнэ. Уг тэмдгийн элементтүүд бол дэлхийн бөмбөрцөг ба түүгээр төсвөлсөн наач бүхий "е" маягийн дурс нь байгаль орчин гэхийг англиар (*environment*), бас "газар" гэхийг (*earth*) буюу ус, ургамал, амьтан, амьдрал нь хэвийн байх, түүнчлэн "хүн-байгаль" хүйн холбоотой гэсэн санааг "наач, дэлхий"-гээр тус тус илтгэн харуулна.

2. Зай талбай, байр, байрлалаас хамаарч, уг эко-тэмдгийн хэлбэр дурс, түүний элементтүүд нь зөв харьцаа бүхий, босоо ба хэвтээ тэнхлэгтээ зөв байршсан, ерөнхий дүрсийн дугуйг доторх үгс нь жижигруулсэн тохиолдолд унших боломжтой байвал зохино.

3. "Eco" –эколог, "MN" – Монгол Улсынх гэсэн санааг тус тус илэрхийлнэ.

4. Өнгөний хувьд "е" хэлбэрийн бөмбөрцөг нь цагаан цэнхэр, түүнд турж орсон "наач" бол ургамлын "ногоон өнгө"-ийг тус тус харуулна. Харин "Байгаль орчинд цэвэр" гэдэг үгсийг хар өнгөөр, гол хэсэгт нь (хоёр захаас нь тэнцүү хэмжээний зай улдээж) бичсэн байвал зохино.

ТӨГСӨВ.